



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

᠑᠐᠑1 оны 0᠖ сарын 14 өдөр

Дугаар А/᠑᠐᠑

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ  
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6. "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 18 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлаж, тэг зогсолт хийсэн А/207 тоот захирамжийг 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 06:00 цагаас эхлэн цуцалж, аймгийн хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, халдварын тохиолдол бүртгэгдсэн сумдуудад 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 06 дугаар 22-ний өдрийг хүртэл хугацаанд дараах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй.

2. Төрийн байгууллагын 10 хүртэл хувийг ажлын байран дээр, бусад алба хаагчдыг гэрээс нь ажиллуулахыг байгууллагын дарга, удирдлагууд, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Архи, согтууруулах ундаа худалдан борлуулах түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжүүдэд согтууруулах ундаа худалдан борлуулах түүгээр үйлчлэхийг тус хугацаанд хориглож, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Хүнсний дэлгүүрүүдийн ажиллах цагийн хуваарийг 09:00 цагаас 18:00 цагийн хооронд ажиллахаар тогтоож халдвар хамгааллын дэглэмийг сахиулж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-т, цагийн хуваарь хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Эмийн сан, хүнсний дэлгүүр, шатахуун түгээх станц, банкуудаас бусад аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дээрх хугацаанд түр хязгаарлаж хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

481210572

6. Хоол хүргэлтийн үйл ажиллагааг зөвшөөрч хяналт тавьж, халдвар хамгааллын дэглэмийг сахиулж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-т үүрэг болгосугай.

7. Хүнсний дэлгүүр, хүргэлтийн хоолны газар, бусад байгууллагуудад урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл хийх арга хэмжээг зохион байгуулахыг Тусгай зөвшөөрөл бүхий байгууллагын удирдлагуудад, түүнд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат)-т тус тус даалгасугай

8. Дамжин өнгөрөх тээврийн хэрэгслийг зогсоохгүйгээр өнгөрүүлэхээр зохицуулж хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар)-т үүрэг болгосугай.

9. Тус хугацаанд халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөн, шаардлагагүй тохиолдолд гэрээсээ гарахгүй байх, олон нийтийн газраар явахдаа маск зүүх, зай барих, гараа ариутгах, мэргэжлийн байгууллага, алба хаагчдаас тавьж буй заавар зөвлөмжийг мөрдлөг болгон ажиллахыг нийт иргэдэд уриалсугай.

10. Дээрх хугацаанд аймгийн хэмжээнд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр нэвтэрч байгаа сүүлийн 4 сарын хугацаанд коронавирусын халдвараар өвчилж эдгэрснээс бусад иргэдийг төлбөртэй түргэвчилсэн шинжилгээнд хамруулж бүрэн тунд хамрагдсан иргэдийг шаардлагатай тохиолдолд тусгаарлах байр, гэрийн ажиглалтад 7 хоног, вакцины бүрэн тунд хамрагдаагүй ПГУ шинжилгээний сөрөг хариу /72 цагийн хугацаанд хүчинтэй/, эсхүл антигенд суурилсан түргэвчилсэн шинжилгээний сөрөг хариу /48 цагийн хугацаанд хүчинтэй/ үндэслэн гэрийн ажиглалтад 7 хоног шилжүүлэн ажиллахыг Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

11. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ